

“Хубилай хааны түүхэнд гүйцэтгэсэн үүрэг”

Хэрээд Жамсрангийн Баясах¹

Хубилай хааны амьдрал, түүний түүхэнд гүйцэтгэсэн үүргийн талаар эрдэмтэн Моррис Россabi тусгайлан судалсан байдаг. Моррис Россabi нь АНУ-ын Нью-Йорк хотын Их Сургуулийн профессор, Колумбын Их Сургуулийн зочин профессор юм. Тэрээр Африкт төрсөн бөгөөд Өрнөдөд боловсрол эзэмшиж, улмаар АНУ-д очиж суурьшсан, ховрой үндэстэн юм. Тэрээр араб, перс, хятад хэл мэддэг тул эдгээр хэлээрх ном зохиолыг өргөн ашигладгаараа давуу талтай нэгэн байж. Тэрээр “Khubilai Khan: His life and times” номыг 1988 онд хэвлүүлсэн байна.

Манай улсад Юань улсаар дагнан судалгаа хийсэн эрдэмтэн бол академич Ч.Далай агсан юм. Тэрбээр “Юань гүрний үеийн Монгол” номыг 1978 онд Улаанбаатар хотноо хэвлүүлж байсан юм. Арван жилийн дараа уг номыг Н.Ц.Мункуевын нэмэлт орчуулгатайгаар, “Монголия в XIII-XIV веках” нэртэйгээр Москва хотноо орос хэлээр хэвлэсэн байдаг. Эрдэмтэн Ч.Далай Бээжингийн Их Сургуулийн түүхийн ангийг төгссөн анхны монгол эрдэмтэн бөгөөд хятад сурвалж өргөнөөр ашигладаг судлаач байсан юм. Тэрээр Юань улсаас гадна Монголын бөө мөргөл, Монгол-Хятадын ХХ зууны сүүлийн хагасын харилцааг судалсан бүтээлүүд гаргасан.

Өдгөө нанхиадач Д.Наран Юань улсын үеийн Монголын төр ёсны боловсролыг судлан гаргаж байгаа бөгөөд 2001 онд нэг сэдэвт зохиол хэвлүүлсэн байна. Тэрбээр мөн Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойгоор “Монголын Юань улс” гэсэн хамтын бүтээл


1. ШУА-ийн Олон Улсын харилцааны хүрээлэнгийн захирал, Түүхийн шинжлэх ухааны доктор /Sc.D/, проф bayasakhjk@yahoo.com

гаргасан юм. Түүнчлэн өнгөрсөн хавар Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагч, өдгөө МУИС-ийн Түүхийн ангийн оюутан Ч.Содбилиг “Монголын Их Юань Улсын түүх” ном бичсэн нь манайд урьд өмнө үзэгдээгүй олзуурхууштай үйл явдал болсон билээ.

Энэхүү илтгэлд байгаа зарим санааг БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шилийн гол аймагт Жаргалсан нөхрийн бүтээн байгуулах гэж буй Хубилай хааны орд, аялал зугаацлын төвд тусган, хэрэгжүүлбэл үүнийг тэрлэгч баярлах болно.

Хубилай хааны угсаа гарал

Чингис хаан хийгээд залгамжлагчид²



Үүнийг Моррис Россابي “Хубилай хаан” хэмээх нэг сэдэвт зохиолдоо гаргасан байдаг. Дээрхээс үзвэл Хубилай хаан алтан ургийн хүн болох нь тодорхой байна. Ах дүү дөрвийн том нь болох Мөнх хаан Гүюг хааны дараа хаан ширээ залгамжилсан түүхтэй. Мөнх хаан ширээнд сууж байхдаа Хубилайд Умард Хятадыг захируулж байсан. Мөнх хааныг өөд болсны дараа Умард Хятадыг захирч их нэр хүндийг олсон. Хубилай 1258 онд хаан ширээнд сууж, 1294 он хүртэл Их Юань гүрний хаан байсан. “Юань” хэмээх улсын нэрийг “өнө” гэдэг үгнээс гаралтай хэмээн Монголын түүхчид үздэг. “Өнө” гэдэг нь өнө мөнхийн “өнө” гэдэг үгнээс гаралтай.

2. Morris Rossabi, “Khubilai Khan: His life and tTimes”, University of California Press, p.19

Мөнх хааныг амьд сэрүүн ахуйд Өмнөд Сүн улсыг Хубилай эзлэхийн тулд өнөөгийн Юнь-нань мужид оршин тогтнож байсан Да-ли улс руу эхлэн довтолж номхотгосны дараа урдаас нь дайрах бэлтгэлийг тэрээр гардан бэлтгэж байсан. Да-ли улс нь жижиг ханлиг байсан агаад Сүн улстай хамтаар Монголын Юань улсын эрхшээлд орсон.

Хубилай хааны ээж Сорхагтани Беки их элдэвтэй сүрхий хатан байсан талаар Плано Карпини, Рашид Аддины номд магтан өгүүлсэн байдаг. Ховрой эмч Бар Хебраус Сорхагтанид зориулан шүлэг зохиосон байдаг бөгөөд түүндээ хатныг “Агуу эмэгтэй” хэмээн бичжээ³. Сорхагтани Беки хатан Хэрэйдийн Ван Ханы ач охин бөлгөө. Түүнийг Чингис хаан хүү Тулуйдаа бэр буулгасан хэмээн түүхэнд тэмдэглэсэн байдаг. Тулуй хааны талаар тэрээр “Аав Чингис хаантайгаа хамт аян дайнд морддог байсан. Их хааныг өөд болсны дараа 1231-1232 онд Тулуй Өгөөдэй хаантай хамт Зөрчидийн эсрэг аян дайнд мордсон бөгөөд Өгөөдэйн өмнөөс бөөгийн ёсоор амиа золиослосон бололтой” гэсэн байдаг. “Монголын нууц товчоон”-д ч Тулуй хэрхэн өөд болсон талаар асар бүрхэг байдаг. Сорхагтани хатан дөрвөн хүүгээ сүрхий хүмүүжүүлсэн бөгөөд хүү нараа хаан ширээнд суулгахын төлөө их зүйл хийж байсан хэмээн түүхэнд тэмдэглэжээ. Үнэхээр ч Өгөөдэйн хүү Гүюг хаан ширээнд тав жил /1246-1251/ суусны дараа 1251 онд Их Хуралдай болж, Мөнх хааныг хаан ширээнд залсан. Мөнх хаан Өмнөд Сүн улсыг эзлэхийн төлөө ихээхэн хүчин чармайлт гаргасан ч уг аянаа гүйцээж чадаагүй. Өмнөд Сүн улсыг эзлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн хүн бол яриангүй Хубилай хаан мөн юм. 1258 онд Мөнхийн дүү Хүлэгү аббасидуудыг дараад Багдад хотыг эзэлсэн. Улмаар тэр Ил Хаан улсыг байгуулж, эзэгнэн суусан.

Хүлэгү дүү Хубилайгаа байнга дэмжиж байсан бөгөөд түүнийг хаан ширээнд суугаад өөд болтол нь Хүлэгүгийн хүүхдүүд өөрөөр хэлбэл Ил Хааны улс Юань гүрнийг ялангуяа Хубилайг дэмжиж байсан. Харин Алтан ордны улс Цагаадайн ач нар Хубилай хааныг дэмждэггүй байсан байх юм. Хубилайг хаан ширээнд суухад Хуралдайг Монголд хийлгүй Умард Хятадад хийсэн тул монгол нутгаа захиран сууж байсан Аригбөх эсэргүүцэж, тэрсэлдсэн талаар түүхэнд бичигдсэн байдаг. Аригбөхийг Зүчи, Цагаадайн хүүхдүүд

3. Ibidium, p.12.


дэмжиж байсан ч Хубилай номхруулж чадсан байдаг. Ил хааны улс нь өнөөгийн Иран, Афганистаныг эзэлж байсан бөгөөд эл улсуудыг нэгтгээд “Перс” хэмээн нэрийддэг. Эдгээр нутгийн хүн ард нь фарси буюу персхэлээр ярьдаг. Эдгээр улсын талаар Рашид Аддин “Судрын чуулган” зохиолдоо дэлгэрэнгүй бичсэн байдаг.

Сорхагтани хатан хоёр дахь хүүгээ хаан болохыг үзсэн байна. Аль аль нь суурин газрын амьдрал ашиг ихтэй болохыг эрт ухаарсан бөгөөд харьяандаа байсан улсыг нэгдсэн бүртгэлд оруулж, данс хараатай болгосон. Ингэснээр татвар авах явдлыг жигдрүүлж, сан хөмрөгөө арвижуулсан. Өмнөд Сүн улсыг эзлэхийн тулд Да-ли улсыг эзлээд уг улсыг Сүн улс руу довтлох түшиц газар болгон иргэдээр нь тариа тариулж байсан хэмээн сурвалжуудад өгүүлсэн байдаг.

Хубилай хаан дөрвөн хатантай байсан тухай тэмдэглэгдэн үлджээ. Бүгд монгол хатад байжээ. Түүнийг ордондоо олон эмс, хүүхэнтэй байсан талаар Марко Поло бичсэн байдаг. Тэдгээр эмстэй цэнгэдэг байсан, тэднийг шалгаруулж авахдаа амьсгалын зам, бие галбир зэргийг нь үзлэгт оруулж авч байсан мэтээр бичсэн байдаг. Дөрвөн хатнаас дөрвөн хүү, хоёр охинтой байжээ. Дөрвөн хатнаас хаантай хамгийн ойр, гол зөвлөдөг хүн нь Чаби хатан байсан тухай ч тэмдэглэсэн байдаг. Чаби хатнаас Жэнзинь, Дорж, Мангалай, Номухан хэмээх дөрвөн хүү төрсөн бололтой. Гэхдээ Хубилай хааны тэргүүн хатан нь Төгүлүн хэмээх эмэгтэй байсан бөгөөд удаах нь Намби гэдэг байж. Түүнээс нэг хүү төрсөн хэмээн түүхчид бичдэг. Дөрөвдэх хатан хэн болох талаар одоохондоо мэдэгдээгүй байна.



Хубилай хааны хөрөг



Чаби хатны хөрөг

Тайваний Үндэсний
музей

Хубилай хааны үйл амьдрал

Хубилай хаан балчир ахуйгаасаа хятад бичиг үсэг сураагүй. Юань улсын эзэн хаан болсон хойноо ч хятад бичиг сураагүй, сурахыг ч оролдоогүй байдаг. Тэрээр өөрийгөө “Даян дээрхи Их хаан” гэж боддог байсан тухай тэмдэглэгджээ. Үнэхээр их гүрний эзэн хаан байсан нь үнэн. Тэр Өмнөд Сүн улсыг эзэлсэн, Солонгосыг төвшитгөж, өөрийн охин Хутулай Чэлимэшийг Солонгосын хаантай ураг барилдуулж, тус улсаас жил бүр “толгой” албанд язгууртан гаралтай хэдэн мянган хүүхдийг барьцаанд байлган хаад, ноёдыг нь номхон байлгадаг аргатай байжээ.

Хубилай хаан Японыг эзлэх гэж хэд хэдэн удаа оролдсон ч далайн шуурганд хэдэн мянган цэргээ алдсан тухай түүхэнд гардаг. Тухайн үед япончууд дотроо хагаралтай байв. Хагаралдуулж байсан нэг тал нь хааны ордныхон, нөгөө тал нь шогуныхан хэмээн тэмдэглэсэн байдаг. Монголчууд усан цэргээ Солонгост бэлтгэж, улмаар 1266, 1271, 1272, 1274 онд Японруу цэрэг хөдөлгөжээ. 1274 оны арваннэгдүгээр сард Бусанаас 15 мянган цэрэг хөдөлгөж байжээ. Солонгосуудаар 300 том онгоц, 400-500 жижиг онгоц бариулж, Кюшо арлын Цүсимад тэдгээр цэргүүд нь газардсан байна. Тулалдааны үеэр далайн шуурга тавьж 13 мянган хүн амиа алдсан байдаг.⁴ Хубилай хаан Япон улсыг эзэлж чадаагүйдээ сэтгэл гонсгор байсан. Аргагүй байдлаас эл төлөвлөгөөгөө хэрэгжүүлж зорилгодоо хүрч чадаагүй юм.

Гэвч Хубилай хаан бүх хятадыг эзэлж, засаг захиргааны ихээхэн өөрчлөлт хийжээ. Харьяа нутагтаа даргучи нарыг томилов. Хятадын уугуул нутгийг захирахдаа монголчууд буюу харь угсаатнаар даргучи тавьж байлаа. Гурван их сайдтай байсны нэг нь лалын шашинтан Ахмад юм. Персийн түүхчид Ахмадыг “Хубилай хаанд үнэнчээр зүтгэдэг байсан” гэж тэмдэглэн үлдээсэн бол хятадын түүхчид түүнийг “Ховдог шунахай сэтгэлтэй, хэрцгий нэгэн байсан” гэжээ.

Сан хөмрөгөө арвилахын тулд бүх хятадын хэмжээнд данс, хараагаа шинэчилж, цаасан мөнгөн тэмдэгтийг хэрэглээнд оруулав. Өргөөний албыг их гүрэн даяар бий болгов. Өмнөд Хятадыг Умард

4. Ibidium, pp. 100-103

Хятадтай холбож, их сувгийг засварлан шинэчилж, уртасгажээ. Газар тариаланд шинэчлэлт хийж, улирал өнжүүлгийн талбайнуудыг бий болгов. Нийслэлээ өнөөгийн Бээжинд авчирч тухайн үедээ Дайдү хэмээн нэрлэдэг байсан ба энэ нь хятадаар “Их нийслэл” юм. Урьд нь Алтан улсын нийслэл Жүндү хэмээх нийслэл байсны суурин дээр Юань гүрний нийслэл Дайдуг байгуулжээ. Хубилай хаан Кайпин хотод дээд нийслэл Шандуг байгуулав. Шанду нийслэлдээ Хубилай зуны цагт суудаг байсан ба тэндээ ан ав хийдэг газартай байжээ. Тэнд гэр босгож, өргөөлөн суудаг байсны дээр бөө сахиус шүтээнээ тахидаг байв.



Хубилай хаан ан хийж байгаа нь, Тайваний Үндэсний музей.

Эдийн засаг, засаг захиргаа, газар тариалангийн шинэчлэлт нь Хятадын уламжлалыг хадгалсан аястай байсан. Уугуул нутагтаа хятад хүнийг хөл тавиулахгүйн дээр тариа тариулж газар хагалуулахгүй, хятад хүнийг суурьшуулахгүй, хятад, монгол хүнийг хооронд нь цус холилдуулахгүй, тэр байтугай хятад хүмүүст монгол хэл заахыг хориглодог байсан. Мөн Юань гүрэнд хийсэн өөр нэг том шинэчлэл нь ард иргэдийг бичиг, үсэгжүүлэхийн зэрэгцээ боловсролын системд өөрчлөлт хийсэн. Уйгаржин монгол бичгээр хятад үсэг, хятад үг, нэр томъёог галиглан буулгахад хүнд байсан учраас Түвдийн Пагва ламыг дэргэдээ залж, дөрвөлжин үсгийг зохиолгуулсан. Дөрвөлжин үсгийг түвд үсгийн суурин дээр зохиосон учраас уг үсгээр хятад үг үсгийг тэмдэглэхэд хялбар байсан. Хубилай хааны зарлигаар дөрвөлжин

“Хубилай хааны түүхэнд гүйцэтгэсэн үүрэг”

үсгийг эзэнт улсын хэмжээгээр хэрэглэх болж зарим хятад бичвэрийг дөрвөлжин үсгээр галиглан бичсэн нь ч бас тааралддаг. Чингисийн үеэс хэрэглэж байсан гэрэгэн дээрхи бичиг нь дөрвөлжин үсгээр бичсэн байдаг. /Зургийг хавсаргав./



*Алтан Ордоны улсын нутгаас олдсон
“Боготолын пайз” гэж алдаршсан хүрэл гэрэгэ*

*“Мөнх тэнгэрийн хүчинд хааны зарлиг хэн
эс биширвээс алдтугай” гэж дөрвөлжин үсгээр
бичжээ.*

Тэр үед хийж байсан шаазан эдлэлийн ёроолд нь дөрвөлжин үсгээр “Юань” гэсэн дардас байдаг⁵. Хубилай хааны үед савлаж байсан дарсны бортог дээр “Сайн дарсун” гэсэн бичиг байдаг.

Сүн улсыг эзэлж авахын тулд мөн Умард Хятадыг захирч эхлэх эхэн үедээ Хубилай хаан хятад зөвлөх олонтой байжээ. Түүний нэр нөлөө өсөхийн хэрээр хятад зөвлөхийн тоог цөөрүүлж, албанд авах явдлыг багасгасан байдаг. Зөвлөхүүдийн олонх нь Күнзийн сургаалтан байсан. Хубилай хаан ширээнд сууж байх эхэн үед бурхны шашинтан хийгээд дао буюу бомбын сургаалтан нар хоорондоо эв түнжин муутай байсныг эвлэрүүлж чадсан байдаг. Хубилай лалын шашинтныг төрийн албандаа их зардаг байсан учраас түүнийг лалын шашныг дэмжигч байсан гэж персийн түүхчид бичдэг. Угтаа бол Хубилай шашныг дэмжиж байсан биш уугуул хятад иргэдийг захирч, хянахын тулд өнгөт нүдтэн, лалын шашинтныг ашиглаж байсан ба тэднийг өөртөө татах аргуудын нэг байсан. Хубилай аливаа нэгэн шашныг гадуурхдаггүй, хүлцэнгүй /tolerant/ ханддаг их хаан байжээ. Тэрээр харийн элч, гийчдийг дотночлон авч уулздаг байсан нь өөртөө татах арга байсан. Тухайлбал, Венецийн худалдаачин Марко Полог ордондоо 18 жил амьдруулсан байдаг. Тэрээр нутаг буцсан ч хааны ордонд буцаад ирсэн байдаг. Эцэст нь энэ хүн “Азиар зорчсон нь” гэдэг гайхалтай ном бичсэн нь өнөөг хүртэл үнэ цэнээ алдаагүй байна.

5. Ж.Баясах, “Хятадын товч түүх”, 141-р тал

Хубилай хаан мөн гар урчуудыг онцгой дэмжих бодлого явуулдаг байжээ. Хубилай хааны үед Балбаас уран дархан авчирч, бүр тагвараас чөлөөлж байжээ. Тухайн үед төмөр, чулуу, арьс, модон урлал их хөгжиж байсны дээр шаазангийн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж, монголчуудын хэрэглэж заншсан “будаатай” шаазанг тэр үеэс хийж эхэлсэн байдаг. Өдгөө Тайваний Үндэсний музейд ёроолдоо дөрвөлжин үсгийн дардастай шаазангуудыг хадгалж байна. Мөн Юань улсын үед “Юаны жүжиг” хэмээх театрын дэг сургууль бий болсон. Өнөө хүртэл уламжилсан байгаа тэр үеийн 57 жүжиг байдаг. Тэр үеийн жүжгийн хэл нь ярианы хэл байсан учраас хятад хэлний бичгийн хэл ярианы хэлийг ойртуулж өгсөн бас нэг сайн талтай байжээ.

ДҮГНЭЛТ

- Хубилай хаан бол алтан ургийн үр удам мөн.
- Суурин ба нүүдлийн соёлыг хослуулахыг оролдсон зүтгэлтэн.
- Шашинд өвөг, дээдэс лугаа адил хүлцэнгүй ханддаг нэгэн байсан.
- Хятадын эдийн засаг, засаг захиргаанд асар их хувь нэмэр оруулсан том гүрний их хаан байсан.


Иймд ӨМӨЗО-ы Шилийн гол аймагт Хубилай хааны ордон барихдаа:

- * Том хүрэл гэрэгэ босгох,
- * Хубилай хаан ав хийж байгаа зургийг байрлуулах,
- * Юань улсад хэрэглэж байсан цаасан мөнгөн тэмдэгтийг үзүүлэн таниулах
- * Юань улсын жүжиг тавих,
- * Зиндэжэний дөрвөлжин үсгийн дардастай шаазан хийж тавих,
- * Монголчууд Японруу усан онгоцоор дайлаар аялж буйг харуулсан уран зураг буюу хөшөө баримал босгох,
- * Монголчууд тэнгэрээ шүтэж, онгодоо дууддаг байсан тул

“Хубилай хааны түүхэнд гүйцэтгэсэн үүрэг”

тахилгын өргөө барьж, дотор нь хүрэл тулга, мөнгөн тогоо бүхий тахилгын гэрийг тахилгын хамтаар босговол таарна. Гэрийн багана луун сийлбэртэй байвал зохино.

Миний судалгаагаар Чингис хаан хийгээд түүний залгамжлагчдын ургийн мод



НОМ ЗҮЙ

1. Morris Rossabi. Khubilai Khan: His life and Times. University of California Press
2. Ж.Баясах. Хятадын товч түүх, Нэн эрт үеэс Дундад Иргэн Улсын эхэн УБ., 2002
3. Ч.Далай Юань гүрний үеийн Монгол. УБ., 1973
4. Ч.Далай. Монголия в XIII-XIV веках. М. 1983
5. Д.Наран. Монголын төр ёсны боловсролын түүх. УБ., 2001
6. Ч.Содбилиг. Монголын Их Юань Улсын түүх. УБ., 2010